

*Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Эрүүл мэндийн даатгал,
Мэдээлэл технологийн албаны дарга”-ын албан тушаалын сонгон шалгаруулалтыг
зарлаж байна.*

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, ЭМДҮЗ-ийн тогтоол, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж иргэн даатгуулагчдад чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх бодлогыг баримтлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эмнэлзүйн чанарын аудит хийх, үнэлгээ дүгнэлт гаргах, асуудлыг шийдвэрлүүлж ажиллах үндсэн үүрэг хүлээхээс гадна байгууллагын мэдээллийн технологи, программ хангамжийн аюулгүй байдал, хөгжүүлэлт, мэдээллийн техник хэрэгслийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулахад хяналт тавин ажиллана.

Ажлын байранд тавигдах ерөнхий шаардлага :

Боловсрол:

Нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны боловсрол олгох их дээд сургуулийг бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй төгссөн.

Мэргэжил:

Хүний их эмч /0912-01/

Уламжлалт анагаах ухааны их эмч/2230-01/

Мэргэшил:

Төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн

Мэргэшлийн ахлах болон түүнээс дээшзэрэгтэй

Эрүүл мэндийн даатгалаар мэргэшсэн байх

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх

Туршлага:

Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх

Ажлын байранд тавигдах тусгай шаардлага:

- Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн байх
- Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн байх
- E-Health программыг бүрэн ашигладаг байх

Сонгон шалгаруулалт явуулах хугацаа:

- Сонгон шалгаруулалт явуулах өдрийг жич зарлана. /Бүртгэлийн өдөр зарлана./

Сонгон шалгаруулалтад орох иргэнийг бүртгэх:

- 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10:00 цагаас
- 2025 оны 06 дугаар сарын 27 өдрийн 17:00 цаг хүртэл бүртгэнэ.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхдээ дор дурдсан материалыг бүрдүүлэн авч ирнэ.

- Төрийн албан хаагчийн анкет /Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын Маягт 1-ээр/
 - Ажил хүссэн өргөдөл
 - Төгссөн их, дээд сургуулийн диплом, бакалаврынхуулбар
 - Урьд нь ажиллаж байсан ажлын газрын тодорхойлолт
 - Иргэний үнэмлэхийн хуулбар
 - Мэргэжлийн диплом, үнэмлэхийн хуулбар
 - Лицензийн хуулбар эх хувийн хамт/Хүний их эмч бол/
 - 4x6 цээж зураг 1 хувь
- Дээрхи шаардлага хангасан материалыг Хүний нөөцийн албанд авчирч өгнө

Мэдээлэл, лавлагаа:

“Эрүүл мэндийн даатгал, Мэдээлэл технологийн албаны дарга”-ын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг Орхон аймаг БОЭТ-ийн www.orkhonboet.moh.gov.mn сайтны “Хүний нөөц” цэсний Нээлттэй ажлын байр хэсэг/-ээс авч болно